



**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2013 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

**Ёс зүйн хороо байгуулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дэргэд төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийн үндэслэлийг хүлээн авч шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий Ёс зүйн хороог доорхи бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

**Ёс зүйн хорооны дарга:**

Ф.Ганбаатар

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

**Гишүүд:**

Н.Цэвээндарь

Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн

Б.Цэцэг

Хяналт шинжилгээний газрын ахлах мэргэжилтэн

Ж.Баатархүү

Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

Л.Батбаяр

Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн

Хоёр. Тус газрын төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган ажиллахыг Ёс зүйн хороо /Ф.Ганбаатар/-нд үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргын 2010 оны 146 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.ЖАДАМБАА

111000